# ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ УДИРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

**Б.ОДБААТАР Ж.МӨНХБАТ**

Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор,цагдаагийн хурандаа

ЦЕГ-ын Төрийн нууцын хэлтсийн жижүүрийн ахлах офицер, удирдахуйн ухааны магистр, цагдаагийн дэд хурандаа

**Хураангуй:**

*Монгол Улсын Засгийн газраас өнгөрсөн 30 жилийн Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч ирэх 30 жилийг урт хугацаагаар төсөөлж хөгжлийн зорилгоо тодорхойлсон “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалыг шинжлэх ухааны судалгаанд суурилан боловсруулж Улсын Их Хурал 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталсан.*

*Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, хөгжлийн стратегийг тодорхойлох асуудал өнөөдөр яригдаж байгаа зүйл биш. Шинэчлэлийг цогц байдлаар хийх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд урт хугацааны хөгжлийн стратеги чухал бөгөөд үүнд Засгийн газар, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлогын дэмжлэг, бүх талын хамтын ажиллагаанд суурилсан идэвхтэй үйл ажиллагаа онцгой үүрэгтэй.*

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах цагдаагмйн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагааг өнөөгийн цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж хөгжүүлэх, “Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримталтай уялдуулан Цагдаагийн байгууллагаас хөгжлийн стратеги хөтөлбөрийг боловсруулах шаардлага бий болжээ.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн бодлогыг тодорхойлоход улс орны гэмт хэрэг, зөрчлийн байдал, шалтгаан нөхцөл, чиг хандлага шууд хамааралтай. Статистик мэдээгээр жилд дунджаар 31 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, 981 хүн нас барж, 10351 хүн гэмтэж, гэмт хэргийн илрүүлэлт сүүлийн 3 жилийн байдлаар авч үзэхэд 2017 онд 35,6 хувь, 2018 онд 36 хувь, 2019 онд 44,9 хувьтай байсан байна[38]. Нийт гэмт хэргийн 65 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгджээ. Гэмт хэргийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээгээр жилд дунджаар 1034 гэмт хэрэг буюу 4.8 хувиар нэмэгдэж байгаа нь 2024 онд 33.5 хувь, 2028 онд 48 4 хувиар өсөх төсөөлөл байна.

Дэлхийн даяарчлал, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, өөрчлөлтөөс хамааран терроризм, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах, хүрээлэн буй орчин, эдийн засаг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг өсөх хандлагатай байна. Эдгээр нөхцөл цагдаагийн байгууллагын стратеги хөтөлбөрийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Цагдаагийн байгууллагын стратеги хөгжлийн төлөвлөлтийг урт хугацаанд, судалгаанд суурилан, тогтвортой хэрэгжүүлэх шаардлага байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, эрүүгийн ба хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийн гаралт, илрүүлэлтийн динамик болон бусад үзүүлэлтээс тод харагдаж байна. Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратегийг боловсруулахад хамаарах хүчин зүйлийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал.
Хүн амын өсөлт, амьжиргааны чадавхи, ажил эрхлэлт.
Гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шалтгаан нөхцөл.
Улс төрийн тогтвортой байдал, нөлөөлөл.

Түүхийн эх сурвалжаас дүгнэхэд цагдаагийн байгууллага хөгжлийнхөө түүхэн явцад 5 удаа хөгжлийн дунд хугацааны болон хэтийн, стратеги хөтөлбөрийг боловсруулж

[38] Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр.

ийнхүү боловсруулах бүрдээ гадаад, дотоод орчинд дүн шинжилгээ хийж, улмаар хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлон, мөн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шаттайгаар боловсруулж байжээ.

Цагдаагийн ерөнхий газар 1996 онд “Ойрын 4 жилд хийх ажлын төлөвлөгөө, дараагийн 4 жилд хийх ажлын бодомж”-ийг гаргаж төв, орон нутгийн бүх газар, хэлтсээр хэлэлцүүлсэн нь хөгжлийн бодлого, чиглэлээ дунд хугацаагаар төлөвлөх анхны алхам болж байжээ. 1998 онд “Цагдаагийн байгууллагын хэтийн төлөвлөгөө" бодлогын баримт бичиг боловсруулсан нь хөгжлийн стратеги хөтөлбөрөө урт хугацаагаар төлөвлөн хэрэгжүүлэх анхны оролдлого болсон байна.

Цагдаагийн байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн он жилүүдэд цагдаагийн байгууллага бүтэц, зохион байгуулалт, хүч хэрэгслийн хувьд бэхжиж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах чадавх дээшилсэн хэдий ч үйл ажиллагааг нь цаашид эрчимжүүлэх, үйлчилгээг чанартай, ил тод, хүртээмжтэй болгох шаардлага байна хэмээн үзэж Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 156 дугаар тушаалаар 2009-2021 он хүртэл хэрэгжүүлэх “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр"-ийг баталж байжээ.

Хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд Хууль зүйн сайдын 2012 оны 11 дүгээрсарын 23-ны А/33 дугаар тушаалаар 2012-2016 онд хэрэгжих “Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг баталж, цагдаагийн төв байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлжээ.

Улсын Их Хурлаас 2013 онд баталсан “Цагдаагийн албаны тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2. дахьхэсэгт“Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийгЗасгийн газарбатална” гэж заасныг үндэслэн Монгол Улсын Засгмйн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор 2014-2019 онд хэрэгжих “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг, Хууль зүйн сайдын 2014 оны А/223 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан, хэрэгжүүлэн ажилласан байна.

Дэлхийн даярчлал, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, өөрчлөлтөөс хамааран терроризм, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах, хүрээлэн буй орчин, эдийн засаг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг өсөх хандлагатай байна. Эдгээр нөхцөл цагдаагийн байгууллагын стратеги хөтөлбөрийг дахин боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг шинээр боловсруулан хэрэгжүүлж байна.

Зураг 1. Цагдаагийн_байгууллагын_хөгжлийн стратеги_боловсруулсан он жилүүд



Цагдаагийн байгууллагын хөгжлийн бодлого, стратеги зорилго, зорилтыг тодорхойлоход улс орны нийгэм эдийн засаг, гэмт хэрэг, зөрчлийн байдал, шалтгаан нөхцөл, чиг хандлага, хүн амын өсөлт, суурьшил, амьжиргааны түвшин, цаашлаад улс төрийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйл шууд хамааралтай байдаг. Мэдээж дээрх хөгжлийн хөтөлбөрүүдийг тухай үеийн нөхцөл байдал, үндэслэлийг судалгаа шинжилгээний үндэслэлтэй авч үзэн стратеги зорилгын хэрэгцээ шаардлагад үндэслэн тухай бүр боловсруулж, улмаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шаттайгаар авч үзсэн байна.

Төрийн албаны тухай хуульд зааснаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсанаас хойш хоёр сарын дотор, дөрвөн жилийн хугацаатай боловсруулж төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар заасан. Энэ хуулийн хэрэгжилтийг хангах, цагдаагийн байгууллагын хөгжлийн хэтийн зорилго, зорилтыг тодорхойлон биелэлт үр дүнг тооцох стратегийн түвшний дараах хөтөлбөрийг Засгийн газраас баталж хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү нийтлэлийн хүрээнд түүний биелэлт үр дүнд шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх талаар Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/223 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр[39] ”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;

2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр[40]”, түүнийг хэрэгжүүлэхээр ЦЕГ-аас 2020 болон 2021 онд баталсан төлөвлөгөө.

**Хүснэгт 1. Стратеги хөтөлбөр боловсруулах үндэслэлийн харьцуулсан судалгаа**

| Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр” | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр” |
|---|---|
| **Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага** | |
| 1. “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т цагдаагийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг орон нутгийн эрх мэдлийн түвшинд зохион байгуулах, төрийн байгууллага, албан хаагчийн эрх, үүргийг боловсронгуй болгож иргэддээ үйлчилдэг ил тод нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх, “Яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлах тухай” Засгийн газрын 2012 оны 63 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т харьяа агентлагийн эрх зүйн шинэтгэлийн талаарх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах зорилтыг дэвшүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуулийг батласнаар хууль сахиулж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээг иргэдэд үзүүлэх үүргийг цагдаагийн байгууллагад хүлээлгэн, хууль сахиулах албаны шинэчлэлийн эхлэлийг тавьсан. | 7. Сүүлийн 3 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, хөдөлгөөн, тархалт, учирсан хохирлын цаашдын чиг хандлагыг нийгэм, эдийн засаг, эрүүгийн нөхцөл байдалтай уялдуулан үзэхэд жилд дунджаар 31 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, 184.8 тэрбум төгрөгийн эд материалын хохирол учирч, 981 хүн нас барж, 10351 хүн бие эрүүл мэндээрээ хохирсон. Дээрх баримтаас дүгнэхэд 2024 онд гэмт хэрэг 41515 буюу 14.6, гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 1135 буюу 21.5 хувиар, зам тээврийн осол 2.9 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 30.0, гэмт хэргийн улмаас нас баралт 10.0, бусдын бие махбодид гэмтэл учруулах зөрчил 15.0 хувиар өсөх хандлагатай гэсэн төсөөлөл байна.<br>8. Цагдаагийн нэг алба хаагчид ногдох хүн амын тоо 371 байгаа нь дэлхийн бусад орны дундаж түвшингээс их ачаалалтай байна.<br>9. Цагдаагийн албаны тухай хууль (шинэчлэн баталсан)-ийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар батална” |

[39] Хөтөлбөрийг 2014-2019 онд а) нэгдүгээр үе шат 2014-2017 он. б) хоёрдугаар үе шат 2017-2019 онд хэрэгжихээр боловсруулсан.

[40] Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

2. Мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг хийх нь цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл (реформ) хийх замаар цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэх

3. Судалгаагаар цагдаагийн байгууллага нь хүнд сурталтай, харьцааны соёлгүй, мэдлэг, мэргэжлийн чадваргүй, иргэдтэй тэгш бус харилцдаг, цагдаагийн удирдлагаас албан хаагчдын ажил үүргийн хараат бус байдалд нөлөөлдөг, танил тал, мөнгөтэй хүнд үйлчилдэг гэж олон нийт дүгнэсэн.

4. Иргэдээс цагдаагийн алба хаагчдыг дорд үзэх, гүтгэх, доромжлох нь ердийн үзэгдэл болсон, ажлын цаг тодорхой бус, гэр бүлдээ анхаарал тавих цаг гардаггүй зэргээс алба хаагчид бухимдах (стресс)-д орж зүй бусаар харьцах байдал гаргадаг болох нь тогтоогдсон.

5. Байгууллагын дотоод, гадаад соёл төлөвшөөгүй, байгууллагын үнэт зүйлийг бий болгож чадаагүй, боловсон хүчнийг сонгон шалгаруулж авах тогтолцоо шинэчлэгдээгүй, менежерийн сонголт учир дутагдалтай бөгөөд удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо бий болоогүй, багаар хамтран ажиллах чадвар муутай, цол, албан тушаалын байдлаар ялгаварлан гадуурхах хандлага бий болсон.

6. Төсөв хомсдолтой, төсвийн зарцуулалт оновчтой биш зэрэг хүчин зүйл нь цагдаагийн байгууллагын бодлого, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг тодорхойлсон үндсэн баримт бичиг болох “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг батлан гаргах үндэслэлийг бий болгосон.

гэж, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 5.4.6-д “Монгол цагдааг хөгжүүлэх, цагдаа иргэдтэйгээ хамтарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ” гэж заасныг үндэслэн мөн дээр дурдсан хэрэгцээ шаардлагыг харгалзан Цагдаагийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”,

10.Хөтөлбөрийг цагдаагийн байгууллагын бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах, удирдах ажилтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх, технологийн шинэчлэл хийх замаар үйл ажиллагааг шуурхай, хүртээмжтэй, дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт хүргэхэд чиглэсэн хөгжлийн зорилго, зорилтыг тодорхойлсон бодлогын баримт бичиг болгох шаардлагатай байгаа.

11.Хөтөлбөр хэрэгжсэнээр цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх сайжирч, алба хаагчдын мэргэжлийн чадвар дээшилж, үйл ажиллагаанд техник, технологийн дэвшлийг өргөнөөр нэвтрүүлэн, Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн гудамж, зам, талбайг камержуулах, хүний нүүр царайгаар таних чадвартай төхөөрөмж (facefinder)-ийг ашиглаж, хүн хүчийг хэмнэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, аюулгүйн бүсүүдийг бий болгох, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, иргэд аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд бодит ахиц, үр дүн гарна гэж үзсэн.

Зураг 2. **Цагдаагийн албаны үнэт зүйл, эрхэм зорилго, уриа, бахархал**




Зураг 3. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр"-ийн зорилго, зорилт



Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн стратеги, түүний хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон дээрх хоёр хөтөлбөрийг харьцуулан авч үзвэл цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг цогц байдлаар хийх, цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, өргөн цар хүрээтэй, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл хийх замаар цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэх, хууль бус хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг олон улсын жишигт хүргэх, алба хаагчдын чадвар, удирдах ажилтны манлайллыг сайжруулахад чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх, үүнд Засгийн газар, Цагдаагийн ерөнхий газрын идэвх оролцоо чухал гэдэгт үндэслэн боловсруулжээ гэж дүгнэж болно.

Нэг. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. 2014-2019 он”-ийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ.

Хөтөлбөрийг боловсруулахдаа цагдаагийн албаны Эрхэм зорилго, уриа, бахархлыг анх удаа дэвшүүлэн дараах байдлаар тодорхойлсон байна.

Хөгжлийн хөтөлбөрөөр Цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг хийж цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэн урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл (реформ) хийх замаар цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэж, ард иргэдийн итгэлийг олж авах, орчин үеийн цагдаагийн загварт шилжих зорилго дэвшүүлэн дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн бий болно гэж үзсэн байна. Үүнд:

- байгууллагын дотоод, гадаад соёл төлөвшинө.
- байгууллагын үнэт зүйл бий болно.
- боловсон хүчнийг сонгон шалгаруулж авах тогтолцоо шинэчлэгдэнэ.
- менежерийн сонголт, удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо сайжирна.
- алба хаагчдын гадаад хэлний мэдлэг дээшилнэ.
- шинэ мэдээлэл олж авах, багаар ажиллах ур чадвар сайжирна гэж үзжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр", түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны биелэлтэд хийсэн дүн шинжилгээгээр:

- o Сайн удирдлага, зохион байгуулалтын зорилтын хүрээнд: 13
- o Мэргэшсэн үйл ажиллагаа зорилтын хүрээнд: 6
- o Эрүүл, чадварлаг хүний нөөц зорилтын хүрээнд: 10
- o Үр ашигтай төсөв, санхүү, хөрөнгө оруулалт зорилтын хүрээнд: 10
- o Олон нийттэй харилцах зорилтын хүрээнд: 8
- o Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын хүрээнд: 6

Хоёр: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. 2020-2024 он”-ийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ:

Зураг 4. Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийн зорилт.



Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг дараах байдлаар тодорхойлон үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах төсөв, хэрэгжүүлэх хугацаа зэргийг нөөц боломждоо тулгуурлан тооцож Хууль зүйн асуудал эрхэлсэн сайдаар батлуулан биелэлт, үр дүнг жил бүр гарган дүгнэж байна.

Монгол Улсын Засгийн газраас "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. 2020-2024 он"-ыг батлаад хэдийгээр нэг жил өнгөрч байгаа ч өнгөрсөн хугацаанд нэлээд ажлыг төлөвлөн биелэлт, үр дүнг ханган ажилласан нь харагдаж байна. Үүнд

Цагдаагийн байгууллагын хөгжлийн бодлого, стратеги зорилго, зорилтыг тодорхойлоход улс орны нийгэм эдийн засаг, гэмт хэрэг, зөрчлийн байдал, шалтгаан нөхцөл, чиг хандлага, хүн амын өсөлт, суурьшил, амьжиргааны түвшин, цаашлаад улс төрийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйл шууд хамааралтай байдаг. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрүүдийг тухай үеийн нөхцөл байдал, үндэслэлийг судалгаа, шинжилгээний үндэслэлтэй авч үзэн стратеги зорилгын хэрэгцээ шаардлагад үндэслэн тухай бүр боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шаттайгаар авч үзсэн нь сайшаалтай.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн стратеги нь мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг цогц байдлаар хийх, цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, өргөн цар хүрээтэй, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл хийх замаар цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэх, хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг олон улсын жишигт хүргэх, алба хаагчдын чадвар, удирдах ажилтны манлайллыг сайжруулахад чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх, үүнд Засгийн газар, Цагдаагийн төв байгууллагын идэвх оролцоо чухал гэдэгт үндэслэн боловсруулжээ гэж дүгнэж байна.

2014 онд баталсан цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрт нийт 53 ажил, арга хэмжээ, 2020 онд баталсан цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн 5 зорилтын хүрээнд нийт 113 ажил, арга хэмжээг төлөвлөсөн байгаагаас дүгнэхэд зайлшгүй стратеги хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлзх гэхээсээ илүүтэй байнгын шинжтэй жил бүр давтагдан явагддаг зарим төрлийн ажил, үйлчилгээ орсон байгаад дүгнэлт хийж, зөвхөн стратеги хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэн хийгдэх томоохон төсөвт ажил, үйлчилгээг тусгаж үе шаттай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна.

**Дэвшүүлэх санал:**

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн "Амар, тайван аюулгүй байдал зорилго"-ын хүрээнд авч хэрэгжүүлэхээр тусгасан ажил, арга хэмжээ нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэгтэй холбогдож байх тул энэ чиглэлээр стратегийн томоохон зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллах шаардлагатай байна. Тухайлбал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр стратеги зорилт дэвшүүлэн үр дүнтэй, үе шаттай бүтээлч ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх.

2020 оны 08 сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т заагдсан ажил арга, хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарч цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дараах ажлыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх нь чухал байна. Үүнд:

1. дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах.
2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх.
3. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон санхүүгийн системийг хөгжэн бүтээлчээр ашиглах.
4. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг анхан шатны

нэгжээс төв байгууллага хүртэл тууштай хангах менежментийн удирдлагын тогтолцоог бий болгож, алба хаагч, шат шатны удирдах ажилтан бүрийн үүрэг оролцоог хангах.


**Эх сурвалжийн жагсаалт**

**Нэг. Хууль эрх зүйн акт.**

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль.

Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.

Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоол. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 36 дугаар тогтоол. “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам” батлах тухай.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр.

**Хоёр. Сурах бичиг, гарын авлага, судалгааны ажлын тайлан**

Я. Шуурав, Д. Ганбаатар. Стратегийн удирдлага. УБ„ 2002.

Б.Энх-Амгалан. “Цагдаагийн байгууллагын нэр хүндийг дээшлүүлэхэд удирдах албан тушаалтны үүрэг оролцоо, анхаарах зарим асуудал". УБ., 2018.

З.Алтангэрэл. “Цагдаагийн удирдах албан тушаалтны манлайлалыг дээшлүүлэхэд анхаарах асуудал” УБ., 2018.

М.Баттулга. “Цагдаагийн байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд анхаарах зарим асуудал” УБ., 2018.

Ч.Мөнхбаатар. “Удирдах албан тушаалтны харилцааны ур чадвар байгууллагын үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх нь (цагдаагийн байгууллагын жишээн дээр)". УБ„ 2018.\

**Гурав. Албан ёсны цахим сайт, цахим эх сурвалж**

Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Цахим эх сурвалж: www.legalinfo.mn

**Дөрөв. Гадаад хэл дээрх сурах бичиг, толь бичиг**

P.J. Ortmeier. Public safety and security Administration. USA. 1999.

Концепция общественной безопасности в Российской Федерации. - М., 20